

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2019.11.20

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан”-г 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн ХЭГ/3000 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр гаргасан болно. Мөн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийг хяналтаас хасах тухай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналыг хавсаргав.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 101 хуулийн 509 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналтанд авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 57 хуулийн 206 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 30 хуулийн 109 хэсэг, заалт буюу 21.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 80 хуулийн /давхардсан тоогоор/ 400 заалт буюу 78.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 41 хуулийн /давхардсан тоогоор/ 97 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	101	509
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	57	206
	- Хяналтанд байгаа	30	109
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	41	97
3	Засгийн газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	80	400

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 30 хуулийн 109 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 16 хуулийн 28 хэсэг, заалт буюу 25.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 24 хуулийн 37 хэсэг, заалт буюу 33.9 хувь нь хэрэгжих шатанд, 19 хуулийн 25 хэсэг, заалт буюу 22.9 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 10 хуулийн 18 хэсэг, заалт буюу 16.5 хувь нь хугацаа болоогүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг, чиглэл өгсөн заалтын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 10 хуулийн 67 хэсэг, заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар ирүүлсэн мэдээнд үндэслэн хуулийн хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 6 хуулийн 27 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 5 хуулийн 41 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 6 хуулийн 27 хэсэг, заалтын хэрэгжилтийг авч үзвэл давхардсан тоогоор 2 хуулийн 5 хэсэг, заалт буюу 18.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 хуулийн 8 хэсэг, заалт буюу 29.6 хувь нь хэрэгжих шатанд, 6 хуулийн 14 заалт буюу 51.8 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Тоо	Хувь
Хяналтанд авсан	10	67		100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	6	27		40.3
Үүнээс:				
- бүрэн хэрэгжсэн	2	5		18.6
- хэрэгжих шатанд	3	8		29.6
- хэрэгжилт хангалтгүй	6	14		51.8
- хэрэгжээгүй	-	-		-
- үнэлэх боломжгүй	-	-		-

2.3. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт

- Агаарын тухай /шинэчилсэн найруулга 2012.05.17/ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

- Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга 2017.05.12/ хуулийн 8 дугаар 8.4.3, 8.4.4, 16 дугаар зүйлийн 16.9, 31 дүгээр зүйлийн 31.1, 32 дугаар зүйлийн 32.1, 34 дүгээр зүйлийн 34.4; дэх хэсэг;
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай /2017.12.08/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, 7.14, 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.3, 14 дүгээр зүйлийн 14.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2.4, 18 дугаар 18.2, 23 дугаар 23.2, 25 дугаар зүйлийн 25.2, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.14, 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.3, 28.4, 28.5, 28.7.1, 28.11, 28.13, 29 дүгээр зүйлийн 29.4, 30 дугаар зүйлийн 30.18, 30.20, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг;
- Малын генетик нөөцийн тухай /2017.12.14/ хуулийн 5 дугаар зүйлийн 5.9, 6 дугаар зүйлийн 6.9, 7 дугаар зүйлийн 7.3, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.6, 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг;
- Баяжуулсан хүнсний тухай /2018.05.03/ хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг зэрэг болно.

2.4. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 6 хуулийн 27 хэсэг, заалтаас дараах 3 хуулийн хэрэгжилтийн явцыг 2018 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэнтэй харьцуулахад хэрэгжилтийн хувь буурсан, давхардаж ирсэн, өмнөх жилүүдэд хяналтаас хасагдсан хуулийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үүнд:

- Усны тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 10 дугаар зүйлийн 10.1.10-т “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах” тухай заалтын хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай гэж үнэлэж байсан бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар 30 хувьтай гэж хэрэгжилтийн хувийг бууруулж ирүүлсэн байна;

- Ус бохирдуулсны төлбөрийн тухай 9 дүгээр зүйлийн 9.3-т “Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батлана” гэсэн өмнөх онд бүрэн хэрэгжиж хяналтаас хасагдсан хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

- Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8 дугаар зүйлийн 8.6.2-т заасан “Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтын хэрэгжилтийн мэдээг 2018 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай гэж ирүүлж байсан бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар 30 хувьтай болон хэрэгжилтийн хувийг бууруулсан;

- Мөн хуулийн 8.7.1-т Хог хаягдлын талаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.7.1. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах;

8.7.2-т Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

8.8.2-т “Хог хаягдлын талаар эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрчим хүчний зохицуулах хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаанаас гарган авсан эрчим хүчний үнийн тооцоог хянах, тарифыг батлах” гэсэн өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хасагдсан заалтуудыг дахин ирүүлсэн байна.

-Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д “Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн, хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэсэн хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүсэн байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 80 тогтоолын 268 заалтыг хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 41 тогтоолын 85 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 20 тогтоолын 49 заалт буюу 18.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 63 тогтоолын 219 заалт буюу 81.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 21 тогтоолын 36 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	80	268
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн <i>Үүнээс:</i>	41	85
	- Хяналтанд байгаа	20	49
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	21	36
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	63	219

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 20 тогтоолын 49 заалтаас давхардсан тоогоор 11 тогтоолын 17 заалт буюу 34.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 7 тогтоолын 19 заалт буюу 38.8 хувь нь хэрэгжих шатанд, 5 тогтоолын 12 заалт буюу 24.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 2 хувь нь хэрэгжээгүй байна.

3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 6 тогтоолын 18 заалтыг

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын 2 тогтоолын 5 заалт буюу 27.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 6 тогтоолын 13 заалт буюу 72.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 2 тогтоолын 5 заалтаас давхардсан тоогоор 2 тогтоолын 2 заалт буюу 40.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 2 заалт буюу 40.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 20.0 хувьтай байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	6	18	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	2	5	27.7
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	2	2	40.0
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	2	40.0
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	20.0
- <i>Хэрэгжээгүй</i>	-	-	-
- <i>Үнэлэх боломжгүй</i>	-	-	-

3.3. Мэдээнд гарсан зөрчил

- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.04.14 №34/ тогтоолын 1.5-д Орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг шалгаж, барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 2017 онд багтаан дуусгах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах ажил 2018 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байсан бол 2019 эхний хагас жилийн байдлаар 30 хувь болон хэрэгжилтийн явцыг бууруулан ирүүлсэн.

- Мөн тогтоолын 1.6-д Барилга байгууламжийн хийц, бүтээц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгдсэн лабораторийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллуулж, орон нутагт сүлжээ бий болгон өргөжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажил 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай бүрэн хэрэгжсэн бол 2019 эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн явцыг бууруулан 70 хувьтай үнэлэн ирүүлсэн.

- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2016.04.14 №34/ 1.4-т. Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн ордонд байрладаг

байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах саналыг боловсруулж 2016 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэсэн хэсэг заалт нь 100 хувьтай хэрэгжсэн гэж ирүүлсэн ч “Төрийн ордны барилгын чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж холбогдох баримт бичгийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн, Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 21-ний хурлаар хэлэлцүүлсэн талаар хэрэгжилтийн явцыг тайлбарлан, гарсан үр дүнг дурдаагүй болно. Улсын Их Хуралд танилцуулаагүй болно.

-Ногоон хөгжлийн бодлого батлах тухай 2014.06.13 №43 тогтоолын 2.3-т “Ногоон хөгжлийн бодлого”-ын биелэлтийг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж байх гэсэн заалтын хэрэгжилтийг 100 хувь гэж ирүүлсэн нь бүрэн хэрэгжсэн гэж үзэх үндэслэлгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж Засгийн газрын хуралдаанд танилцуулан холбогдох тайланг Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлнэ гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтанд байгаа нийт 6 тогтоолын 18 заалтаас давхардсан тоогоор 6 тогтоолын 13 заалт буюу 72.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байгаа нь Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,

- Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2012.12.28 №74 тогтоолын 2.5 дахь заалт;
- Ногоон хөгжлийн бодлого батлах тухай 2014.06.13 №43 тогтоолын 2.1 дэх заалт;
- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай 2016.04.14 №104 тогтоолын 2 дахь заалт;
- Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 2016.02.04 №13 тогтоолын 2 дахь заалт;
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016.04.14 №34 тогтоолын 1.2 дахь заалт;
- Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018.01.05 №02 тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 2.1 дэх заалтуудын хэрэгжилт ирээгүй байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 98 тогтоолын 668 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

2019 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 33 тогтоолын 138 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтанд байгаа 19 тогтоолын 51 заалт буюу 7.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 91 тогтоолын 617 заалт буюу 92.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол	Заалт
1	2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд авсан	98	668
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн <i>Үүнээс:</i>	33	138
	- Хяналтанд байгаа	19	51
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	29	87
3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	91	617

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 19 тогтоолын 51 заалтаас 5 тогтоолын 7 заалт буюу 13.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 14 тогтоолын 28 заалт буюу 54.9 хувь нь хэрэгжих шатанд, 8 тогтоолын 12 заалт буюу 23.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 3 тогтоолын 4 заалт буюу 7.9 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 29 тогтоолын 87 заалтын мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 15 тогтоолын 70 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтанд байгаа тус Байнгын хорооны 2 тогтоолын 2 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 15 тогтоолын 68 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БОХХААБХ-ны	Заалт	
	тогтоол /давхардсан тоогоор/	Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	15	70	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	2	2	2.9
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	-	-	-
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	1	50.0
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	1	1	50.0
- <i>Үнэлэх боломжгүй</i>	-	-	-

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 2 тогтоолын 2 заалтаас давхардсан тоогоор 1 тогтоолын 1 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 50.0 хувь нь хэрэгжилт хангалтгүй мэдээг ирүүлсэн байна.

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтанд байгаа нийт 15 тогтоолын 70 заалтаас дараах 15 тогтоолын 68 заалт буюу 97.1 хувийн хэрэгжилтийн

мэдээг ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал,

1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /2010.11.12 №07/ тогтоолын 1.1, 1.6, 1.7, 1.8 дахь заалт;
2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний тухай /2012.12.06 №05/ тогтоолын 4, 1./МХЕГ-т/, 1./УМБГ-т/, 1./Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д/, 2 дахь заалт;
3. Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай /2014.01.15 №04/ тогтоолын 1.3/ дахь заалт;
4. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн нөхөн сэргээлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2014.04.29 №07/ тогтоолын 1.2/, 1.3/ дахь заалт;
5. Байгаль орчны төлөв байдлын 2013-2014 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2015.05.06 №05/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.8/, 2 дахь заалт;
6. Чиглэл өгөх тухай /2016.01.22 №01/ тогтоолын 1.2/ дахь заалт;
7. Чиглэл өгөх тухай /Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016.02.03 №1/ тогтоолын 1.1/, 1.2/ дахь заалт;
8. Чиглэл өгөх тухай /Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2017.02.08 №01/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 2 дахь заалт;
9. Байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2017.05.16 №05/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт;
10. Чиглэл өгөх тухай /2018.05.16 №06/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт;
11. Агаарын бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай /2018.05.30 БОХХААБХ/НББСШУБХ-ны хамтарсан №07/16/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 2 дахь заалт;
12. Чиглэл өгөх тухай /2018.11.02 №08/ тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 1.6/, 1.7/, 1.8/, 1.10/, 1.11/, 1.12/, 2 дахь заалт,
13. Засгийн газарт чиглэл өгөх тухай /БОХХААБХ/ӨБХ/ 2019.05.28 №04/01 тогтоолын 1.1/, 1.2/, 1.3/, 1.4/, 1.5/, 2 дахь заалт тус тус байна.

Мөн сүүлийн онуудын тогтоолын хэрэгжилт ирүүлээгүй, тогтоолын заалтуудыг давтан ирүүлэх зөрчлүүд гарч байна.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 2 хуулийн 4 хэсэг, заалт, заалтыг хяналтаас хасах санал ирүүлснийг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг

тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах 4 хуулийн 40 хэсэг, заалт буюу **59.7** хувь, Улсын Их Хурлын 4 тогтоолын 13 заалт буюу **81.7** хувь, Байнгын хорооны 15 тогтоолын 68 заалт буюу **97.1** хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлэх, хэрэгжилтийн хувь хэмжээг өмнөх оноос бууруулж үнэлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй зэрэг зөрчил байна.

3/ Улсын Их Хурлын Тамгын газраас хагас жил тутам хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд хяналт шинжилгээ хийж, тодорхой санал, зөвлөмжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг боловч тухайн санал зөвлөмжийг ажил хэрэг болгохгүй байгаа нь хэрэгжилтийн мэдээнээс харагдаж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЖАГСААЛТ
/2019 оны эхний хагас жилийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1.	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.01.29	21.4.Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Төмс, хүнсний ногооны хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалын төслийг ХААИС, Дарханы Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн эрдэмтэд, Монголын хөдөөг шинэчлэхийн төлөө фермерүүдийн холбоо, ногоочдын холбоо зэрэг төрийн бус байгууллага, ногоочдын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлсэн. Төслийг хэлэлцсэн баримтын хамт Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулсан. Уг аргачлалыг ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-43 дугаар тушаалаар батлуулсан.
2.	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.05.12	7.1.4. Монгол Улсад импортлохыг хязгаарласан болон хориглосон зарим хог хаягдлын жагсаалт батлах;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтад нэмэлт оруулах тухай Засгийн газрын 378 дугаар тогтоолд нэмэлт оруулж, тогтоолыг батлуулсан.
		8.1.13. Дахин боловсруулах боломжтой түүхий эд болон дахивар нөөцөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний таних тэмдгийн стандартыг эрх бүхий байгууллагаар батлуулах;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Олон улсын стандартчиллын байгууллагаас баталсан ISO16075. Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах зааврын төсөл, Олон улсын хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /FAO/, АНУ, Израйль, Итали, Хятад зэрэг орны дахин ашиглах усны стандарт, арга аргачлалуудыг судлан үзэж, Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6734 стандартыг боловсруулж, 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдөр Стандарт хэмжил зүйн газраар үндэсний стандартыг батлуулсан. Уг стандартад дахин ашиглах усны системийн бүх шугам хоолой, тоноглол, хэрэглэх цэгүүд дээр тэмдэг, шошго байрлуулах бөгөөд уг шошго нь нил ягаан өнгийн дэвсгэр дээр хар өнгийн үсгээр “Анхаар- цэвэрлэсэн хаягдал ус, уухыг хориглоно” гэсэн таних тэмдэг, тэмдэглэгээг 10 метр тутамд байрлуулахаар тусгасан болно.
		8.1.14. Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.	Сангийн яам Хог хаягдлын тухай хуулийн 8.1.14-т заасан Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт-ыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2018 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А/30, 33 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд жагсаалтын төслийг боловсруулж, Хоёр сайдын 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А-429/257 дугаартай хамтарсан тушаалаар баталсан.
Нийт 2 хуулийн 4 хэсэг, заалт;			

